

БАТЛАВ.

УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ
 ГАЗРЫН ДАРГА С.МЭНДСАЙХАН

**УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2016.02.15.

№	Үйл ажиллагааны зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт			Хариуцах нэгж	Хүрэх үр дүн	
			Нөөц		Хугацаа			Гүйцэтгэлийн шалгуур
			Хүн хүчин	Хөрөнгө санхүү				
Нэг. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт								
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, холбогдох мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;	<p>1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудсаар сурталчилах, нээлттэй өдөрлөг зохион байгуулах, албан хаагчдад яриа таниулга хийх;</p> <p>1.2.Авлигатай тэмцэх газар/АТГ/-аас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материал, гарын авлагыг албан хаагчдад танилцуулах, иргэдэд тараах;</p>	Хүн/өдөр	Гүйцэтгэлээр	<p>Жилдээ</p> <p>Хууль тогтоомжийг сурталчилсан байна.</p>	Газар, хэлтсийн дарга нар	Ил тод нээлттэй орчин бий болсон байна.	
				Тухай бүр	Сурталчилгааг танилцуулсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар		
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох;	<p>2.1. Боловсруулж байгаа хууль, дүрэм, журмын төсөлд байгууллагын цахим хуудсаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх;</p> <p>2.2.Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулах, иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх;</p>	Хүн/өдөр	Шаардлагагүй	Тухай бүр	<p>Цахим хуудсанд хууль, дүрэм, журмын төслийг байршуулж, олон нийтийн саналыг цахим хуудсаар авах нөхцөл бүрдүүлсэн байна.</p>	<p>Нэгдсэн бодлого, хамтын ажиллагааны газар,</p> <p>Мэдээллийн боловсруулалт, технологийн газар,</p> <p>Төрийн захиргаа, удирдлагын газар</p>	Иргэд олон нийтийн саналыг хууль тогтоомжид тусгасан байна.

3.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	<p>3.1.Байгууллагын үйл ажиллагааны 2016 оны хяналт, шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах;</p> <p>3.2.Хийсэн хяналт шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах;</p> <p>3.3.Хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах/-ний үр дүнгийн талаар цахим хуудсаар мэдээлсэн байх;</p>	Хүн/өдөр	Шаардлагагүй	Жилдээ	Төлөвлөгөө боловсруулж хяналт тавьж ажилласан байна.	Хяналт, шинжилгээ үнэлгээний газар	Хариуцлагын тогтолцоо бий болно.
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	<p>4.1.Байгууллагын жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 25-ны дотор/ -ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах;</p> <p>4.2. Сар, улирлын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногт/, төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбар /улирал бүр/-ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах;</p> <p>4.3. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл, хагас жилийн санхүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/, дараа жилийн төсвийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/, Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /7 дугаар сарын 1-ний дотор/-г цахим хуудсанд байршуулах;</p> <p>4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон</p>	Хүн/өдөр	Шаардлагагүй	<p>I –II улирал</p> <p>Тухай бүр</p> <p>III улирал</p>	Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.	Мэдээллийн боловсруулалт, технологийн газар, Санхүүгийн хэлтэс	Тогтолцооны шударга байдал хангагдана.

		<p>өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш мөнгөн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор/, байгууллагын орон тоонд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах;</p> <p>4.5.Төсвийн орлого бүрдүүлэлтийн /татварын орлого, татварын бус орлогын талаарх/ мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах;</p> <p>4.6.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй байлгах;</p>			Тухай бүр			
					Жилдээ			
					Жилдээ			
5.	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>	<p>5.1.Улсын бүртгэл, статистикийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулах;</p> <p>5.2.Бүртгэл хөтлөх журам, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг байгууллагын цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах;</p>	Багаар	Гүйцэтгэлээр	Жилдээ	Хэвлэл мэдээллээр сурталчилсан байна.	Мэдээллийн боловсруулалт, технологийн газар, Мэдээлэл, сургалт сурталчилгааны төв	Иргэд, олон нийт мэдээллээр хангагдсан байна.
6.	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>6.1.Байгууллагын ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах;</p> <p>6.2.Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх;</p>	Хүн/өдөр	Шардлагагүй	Тухай бүр	Нийтэд зарлан мэдээлсэн байна.	Мэдээллийн боловсруулалт, технологийн газар, Хүний нөөцийн хэлтэс	Хүний нөөцийн бодлого ил тод, шударга болно.
		7.1.Байгууллагын 2016 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,	Хүн/өдөр	Шардлагатай	Тухай бүр	Төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан байна.		

7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	<p>ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах /1 дүгээр сарын 10-ны дотор/;</p> <p>7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах;</p> <p>7.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгааныг цахим хуудсанд байршуулах;</p> <p>7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсанд байршуулах;</p> <p>7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах;</p> <p>7.6.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах;</p>				<p>Тендерийн урилга, баримт бичгийг цахим хуудсанд байршуулсан байна.</p> <p>Холбогдох мэдээллийг байршуулсан байна.</p> <p>Тайлан, дүгнэлт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулсан байна.</p> <p>Үнэлгээний хороонд холбогдох төлөөллийг оролцуулсан байна.</p>	Мэдээллийн боловсруулалт, технологийн газар, Санхүүгийн хэлтэс	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.
8.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	<p>8.1. УБСЕГ-ын даргын тушаалаар байгууллагын албан хаагчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, мөрдөх;</p> <p>8.2. Шинээр ажилд томилогдсон төрийн албан хаагч бүрийг ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьтай танилцуулж, мөрдүүлэх;</p>	Хүн/өдөр	Шаардлагагүй	Тухай бүр	Албан хаагчдад ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулсан байна.	Хүний нөөцийн хэлтэс	

		8.3. Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаар нээлттэй болгох;			II улирал	Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.		
9.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгуулага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	9.1. Улсын бүртгэл, статистикийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх;	Багаар	Гүйцэтгэлээр	III улирал	Иргэний нийгмийн байгууллагаар судалгаа хийлгэсэн байна.	Нэгдсэн бодлого, хамтын ажиллагааны газар	
		9.2. Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар мэдээлсэн байх;			III улирал	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж, цахим хуудсаар мэдээлсэн байна.		
10.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	10.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалын байдал, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах, цалингийн урамшуулал олгох;	Хүн/өдөр	Гүйцэтгэлээр	II улирал	Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгагдсан байна. Сейф, лац,, цахим сүлжээ, компьютер бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.
		10.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад идэвхитэй хамрагдах, үр дүнтэй ажиллах;			Шаард- лагагүй	Жилдээ		
11.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	11.1. “УБСЕГ-ын ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлах, мөрдүүлэх, цахим хуудсанд байршуулж, албан хаагчдад танилцуулах;	Хүн/өдөр	Шаард лагагүй	Жилдээ	Ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, батлан, цахим хуудсанд байршуулсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар,	Хувь хүний шударга байдал, ёс зүйд ахиц гарсан байна.
		11.2. Нэгж бүрт үйл ажиллагаа, албан хаагчдын ёс зүйн байдлын талаарх санал хүсэлтийг хүлээн авах утас болон санал хүсэлтийн хайрцаг байршуулах, түүний хэрэгжилтийг тайлагнах;			I улирал	Санал хүсэлтийн хайрцаг байршуулж, утас ажиллуулсан байна.		

		11.3. Ёс зүйн зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг Зөвлөмж өгөх хэлбэрээр авах, Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж, хамт олонд мэдээлэх;			Жилдээ	Ёс зүйн зөрчлийг арилгасан байна.		
12.	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	12.1. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах; 12.2. Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа гаргаж, албан хаагчид давхар ажил эрхлэх тохиолдолд Төрийн захиргаа, удирдлагын газраас зөвшөөрөл авах;	Хүн/өдөр	Шаардлагагүй	II улирал Жилдээ	Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, танилцуулсан байна. Давхар ажил эрхлэлтийн талаар судалгаа гаргасан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар, Хүний нөөцийн хэлтэс	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.
13.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	13.1. Байгууллагын удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсанд байршуулах; 13.2. Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийн болон статистикийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулах; 13.3. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудсанд байршуулах;	Хүн/өдөр	Шаардлагагүй	Тухай бүр	УБЕГ-ын даргын нийтэд хамаарах тушаал, шийдвэр, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмыг цахим хуудсанд байршуулсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар, Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв	Байгууллагын үйл ажиллагаа ил тод нээлттэй болсон байна.
		14.1. УСБЕГ-ын хуулиар тогтоосон эрхлэх асуудлын талаар болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;	Хүн/өдөр		Жилдээ	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.	Байгууллагын удирдлага	

14.	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	<p>14.2. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр болон утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факсаар хүлээн авч шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;</p> <p>14.3. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах албан хаагчийн нэр, албан тушаал, утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах;</p> <p>14.4. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх;</p>		Шаардлагагүй	Жилдээ	Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх нөхцөл боломжийг хангасан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар, Мэдээлэл, сургалт сурталчилгааны төв	Иргэд олон нийтэд бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэсэн байна.
15.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	<p>15.1. Авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаалыг тодорхойлох судалгааны ажлыг бусад хөндлөнгийн байгууллагаар хийлгэх. Түүний дагуу урьдчилан сэргийлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>15.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээний шат дамжлагыг багасгах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг судлах, нэвтрүүлэх, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	Багаар	Гүйцэтгэлээр	II улирал	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар, Хүний нөөцийн хэлтэс	Хувь хүний шударга байдал, ёс зүйд ахиц гарсан байна.
		16.1. АТГ-аас зөрчил арилгуулахаар болон хариуцлага тооцож арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;	Багаар	Шаардлагагүй	Тухай бүр	Ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авсан байна.	Хүний нөөцийн хэлтэс Хяналт, шинжилгээ үнэлгээний газар	

16.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	16.2. АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийг биелүүлэх, арга хэмжээ зохион байгуулах;	Хүн/өдөр	Шаардлагагүй	Тухай бүр	Ирүүлсэн мэдэгдлийн дагуу гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгасан байна.	Хяналт, шинжилгээ үнэлгээний газар	Авлигын эсрэг хууль тогтоомж хэрэгжилт хангагдаж, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нөхцөл боломж бүрдэнэ.
		16.3. Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгож, хууль тогтоомжийг боловсронгуй болгох;			Жилдээ	Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан байна.		
		16.4. АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах;			Тухай бүр	Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна.		

Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга

17.	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	17.1. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаандаа хэрэгжүүлж ажиллах;	Хүн/өдөр	Шаардлагагүй	Жилдээ	Төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Байгууллагын удирдлага,	Байгууллагын албан хаагчид болон олон нийтэд шударга байдлын итгэл үнэмшил бий болно.
		17.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх саналыг тайланд тусгасан байх;			IV улирал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлсэн байна.		
18.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	18.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгад нэгдэх,	Хүн/өдөр	Гүйцэтгэлээр	Жилдээ	Санал, санаачилгад нэгдсэн байна.	Газар, хэлтсийн дарга нар	
		18.2. Байгууллагын удирдах албан тушаалтнууд /Газар, хэлтсийн дарга нар/			Жилдээ	Авлигын эсрэг ажлыг шинээр санаачлан хэрэгжүүлсэн байна.		

		авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлаа илэрхийлж нэгээс доошгүй ажил шинээр санаачилж зохион байгуулах;						
		18.3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг байгууллагын төсөвт тусган санхүүжүүлэх;			Жилдээ	Авлигын эсрэг үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.	Санхүүгийн хэлтэс	
19.	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	19.1. Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулах;	Багаар	Гүйцэтгэлээр	Жилдээ	Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	Төрийн захиргаа, удирдлагын газар, Мэдээлэл, сургалт сурталчилгааны төв	Хувь хүний шударга байдал, ёс зүйд ахиц гарсан байна.
		19.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;	Хүн/өдөр	Шаардлагагүй	Жилдээ	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг зөв үнэлсэн байна.	Хяналт, шинжилгээ үнэлгээний газар	
		19.3. Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчилд арга хэмжээ авч, албан хаагчдад цахим хуудсаар мэдээлэх;			Жилдээ	Авлигын зөрчилд арга хэмжээ авсан байна.		
		19.4. Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчилд арга хэмжээ авч, цахим хуудсаар мэдээлэх;			Жилдээ	Авлигын зөрчилтэй холбоотой асуудлыг арилгах арга хэмжээ авах		
		19.5. Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчлийг арилгах арга хэмжээ авах.			Жилдээ	Авлигын зөрчилтэй холбоотой асуудлыг арилгах арга хэмжээ авах		

УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААДОРЖ

ХЯНАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ш.ОЮУНГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГАА,
УДИРДЛАГЫН ГАЗАР

Ц.ОЮУНБИЛЭГ
2016.03.15